

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2021 оны 12 дугаар сарын 30 –ны өдрийн  
17 дугаар тогтоолын хавсралт



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН  
“ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”

## **Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам**

### **1. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК (цаашид “Бирж” гэх)-ийн гишүүн үнэт цаасны компанийг “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 47 дугаар зүйл, 70 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8.3 дугаар заалтын дагуу зах зээл үүсгэгчээр бүртгэж гэрээ байгуулах, гэрээг түдгэлзүүлэх, цуцлах болон зах зээл үүсгэгчид тавих хяналт түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа нь үнэт цаас гаргагч болон Биржтэй гэрээ байгуулсны үндсэнд тодорхой үнэт цаасны худалдах, худалдан авах үнийн саналыг энэхүү журамд заасан нөхцөлийн дагуу нэгэн зэрэг гаргах замаар өөрийн хөрөнгөөр эсвэл урьдчилан тогтоосон этгээдийн хөрөнгөөр арилжаанд оролцож, тухайн үнэт цаасны эрэлт, нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааг хэлнэ.
- 1.3 Биржид бүртгэлтэй хувьцаа, өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжаанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг явуулна.
- 1.4 Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд, Бирж нь хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцүүлэн журмыг тайлбарлах эрхтэй байна.

### **2. Зах зээл үүсгэгчид тавих шалгуур, шаардлага**

- 2.1 Зах зээл үүсгэгч нь зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх болон бүртгэлтэй байх хугацаанд дараах шалгуур, шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:
  - 2.1.1 Биржийн гишүүн байх;
  - 2.1.2 Өөрийн хөрөнгийн хэмжээ 1 тэрбум төгрөгөөс доошгүй байх;
  - 2.1.3 Зах зээл үүсгэх үйл ажиллагааны эрсдлийн удирдлага, сонирхлын зөрчил зэргийг зохицуулах дотоод хяналтын найдвартай систем, программ хангамж, дүрэм журамтай байх;
  - 2.1.4 Сүүлийн 1 жилийн хугацаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журмын зөрчил гаргаагүй байх;
  - 2.1.5 Зохицуулалттай үйл ажиллагааг нэгээс доошгүй жилийн хугацаанд явуулсан, компани болон ажилтан нь сүүлийн 3 жилийн хугацаанд холбогдох хууль тогтоомжийн ноцтой зөрчил гаргаагүй байх;
  - 2.1.6 Биржийн “Гишүүнчлэлийн журам”-д заасан төлбөр, хураамжийн өр төлбөргүй байх.

### **3. Зах зээл үүсгэгчээр бүртгэх хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх**

- 3.1 Бирж нь хөрвөх чадвар хангалтгүй үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор энэхүү журмын 2.1-д заасан шаардлага хангасан гишүүн үнэт цаасны компанийг зах зээл үүсгэгчээр сонгож, Зах зээл үүсгэх гэрээ байгуулж болно.



- 3.2 Энэхүү журмын 3.1-д заасны дагуу зах зээл үүсгэгчийг сонгохдоо нийт гишүүдэд урьдчилан мэдэгдэж, шударга, ил тод байдлаар сонгон шалгаруулна.
- 3.3 Энэхүү журмын 3.1-д зааснаас гадна зах зээл үүсгэгч нь үнэт цаас гаргагчийн хүсэлтээр таваас ихгүй тооны үнэт цаасны зах зээлийг үүсгэж болох ба үнэт цаас бүрийн зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх хүсэлтийг энэхүү журмын Хавсралт 1-ийн дагуу Биржид гаргах бөгөөд Бирж хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.
- 3.4 Зах зээл үүсгэгчээр бүртгэх эсэх шийдвэрийг Биржийн Гүйцэтгэх захирал гаргаж, гэрээ байгуулна.
- 3.5 Бирж нь дараах тохиолдлуудад хүсэлт гаргагчийг зах зээл үүсгэгчээр бүртгэхээс татгалзана. Үүнд:
- 3.5.1 Энэхүү журмын 2.1 дэхь заалтанд заасан шалгуур, шаардлагуудыг хангаагүй;
- 3.5.2 Хүсэлт гаргахаар ирүүлсэн баримт материал бүрэн бус, алдаатай эсхүл хуурамч болох нь тогтоогдсон;
- 3.5.3 Хүсэлтийг шалгаж байх хугацаанд тухайн гишүүний арилжаанд оролцох эрхийг хязгаарлах, гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлэх зэрэг шийдвэр гарсан;
- 3.5.4 Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл.
- 3.6 Биржийн Гүйцэтгэх захирал нь зах зээл үүсгэгчээр бүртгэхээс татгалзсан шийдвэрийг тайлбарын хамт хүсэлт гаргагч гишүүнд бичгээр хүргүүлнэ.

#### **4. Зах зээл үүсгэгчийн хүлээх үүрэг, хариуцлага**

- 4.1 Зах зээл үүсгэгч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 4.1.1 Арилжааны системд оруулах худалдах, худалдан авах захиалга тус бүрийн доод хэмжээ нь гэрээнд заасан үнэт цаасны 1000 ширхэг эсвэл 500 мянган төгрөгтэй тэнцэхүйц үнийн дүнтэй байна.
- 4.1.2 Худалдах болон худалдан авах захиалгын үнийн түвшинг тухайн үнэт цаасны сүүлийн ханшаас дараах хязгаарыг хүртлэх хүрээнд тогтооно. Үүнд:
- 4.1.2.1 Хөрвөх чадвар харьцангуй сайн /Биржийн бүртгэлийн 1-р ангилал, өрийн хэрэгсэл, ХБҮЦ, бусад санхүүгийн хэрэгсэл/: 2%
- 4.1.2.2 Хөрвөх чадвар дунд /Биржийн бүртгэлийн 2-р ангилал, сангийн нэгж эрх/: 3%
- 4.1.2.3 Хөрвөх чадвар сул / Биржийн бүртгэлийн 3-р ангилал/: 5%
- 4.1.3 Арилжааны өдөр бүр энгийн арилжааны цагийн 50%-иас доошгүй хугацаанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 4.1.4 Арилжааны системд оруулж буй худалдах болон худалдан авах захиалгын дүн нь хэт зөрүүгүй байх нөхцөлийг хангана.
- 4.1.5 Арилжааны системд оруулах захиалгыг бусад энгийн захиалгаас ялгагдахуйц тусгай тэмдэглэгээтэй оруулах эсхүл гишүүний өөрийн нэр дээр тусгайлан нээсэн данснаас арилжаанд оролцоно.
- 4.1.6 Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа нь харилцагчтай сонирхлын зөрчил үүсгэх тохиолдолд энэ талаар харилцагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 4.1.7 Зах зээл үүсгэх үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг бусад захиалгын баримт материалаас тусгаарлаж, зохих бүртгэлийг хөтөлж, гурваас доошгүй жилийн хугацаанд хадгална.



4.1.8 Энэхүү журмын 2.1-д заасан шалгуур, шаардлагатай холбоотой үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийг Биржид ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

## **5. Зах зээл үүсгэгчийн гэрээг түдгэлзүүлэх**

5.1 Бирж нь дараах тохиолдлуудад зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг түдгэлзүүлнэ. Үүнд:

- 5.1.1 Тухайн гишүүний арилжаанд оролцох эрхийг хязгаарласан, гишүүнчлэлийн эрх болон тусгай зөвшөөрөл түдгэлзсэн;
- 5.1.2 Зах зээл үүсгэх үнэт цаасны арилжааг түр зогсоосон;
- 5.1.3 Энэхүү журам болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;
- 5.1.4 Гэрээг түдгэлзүүлэх хүсэлтийг 14 хоногийн өмнө гаргасан;
- 5.1.5 Тухайн гишүүнд Биржийн “Хяналт шалгалтын журам”-ын дагуу хяналт, шалгалт явуулж эхэлсэн.

5.2 Энэхүү журмын 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.5-д заасан нөхцөл бий болсон даруй зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг түдгэлзүүлсэнд тооцно.

5.3 Бирж нь дараах тохиолдлуудад зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг цуцална. Үүнд:

- 5.3.1 Зах зээл үүсгэгч гэрээг цуцлах хүсэлт 30 хоногийн өмнө гаргасан;
  - 5.3.2 Зах зээл үүсгэгч энэхүү журамд заасан шалгуур, шаардлагыг хангахгүй болсон;
  - 5.3.3 Гэрээг удаа дараа зөрчсөн;
- 5.4 Бирж нь энэхүү журмын 5.3.2, 5.3.3-т заасны дагуу гэрээг цуцалсан тохиолдолд түүний үндэслэлийг зах зээл үүсгэгч гишүүнд мэдэгдэнэ.

## **6. Онцгой нөхцөл байдал**

6.1 Зах зээл үүсгэгч нь дараах тохиолдлуудад энэхүү журамд заасан үүргээс чөлөөлөгдөж болно. Үүнд:

- 6.1.1 Ханшийн хэт хэлбэлзэл: Тухайн үнэт цаасны ангиллын индекс, ангиллын индекс байхгүй бол Биржийн ТОП-20 индекс сүүлийн нэг сарын хугацаанд 30%-иар өөрчлөгдсөн;
- 6.1.2 Дайн, үймээн самуун, бослого тэмцэл, цахим халдлага, цар тахал гэх мэт онцгой нөхцөл байдал үүссэн;
- 6.1.3 Биржийн арилжааны системд алдаа, гэмтэл, саатал үүссэн;

6.2 Дараах тохиолдолд зах зээл үүсгэгчийн худалдах, худалдан авах захиалгын үнийн зөрүүг энэхүү журмын 4.1.2-т заасан хэмжээнээс 2 дахин нэмэгдүүлэх, захиалгын доод хэмжээг 2 дахин бууруулах хөнгөлөлтийг үзүүлж болно. Үүнд:

- 6.2.1 Тухайн үнэт цаасны ангиллын индекс, ангиллын индекс байхгүй бол Биржийн ТОП-20 индекс 10-аас дээш хувиар хэлбэлзэж эхэлбэл тухайн өдөртөө болон арилжааны дараагийн өдөрт;
- 6.2.2 Энэхүү журмын 6.1.1-д заасан нөхцөл.
- 6.2.3 Биржээс зөвшөөрсөн бусад тохиолдолд.

## **7 Хариуцлага**

- 7.1 Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгж энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд хяналт шалгалтын журамд заасан үндэслэл, чиглэлийн дагуу зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 7.2 Зах зээл үүсгэгч нь энэхүү журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:
  - 7.2.1 Сануулах
  - 7.2.2 Үзүүлсэн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэсэгчлэн болон бүтнээр нь буцаан төлүүлэх;
  - 7.2.3 Гэрээг цуцлах;
  - 7.2.4 Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах;
  - 7.2.5 Гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлэх;
  - 7.2.6 Гишүүнчлэлийн эрхийг цуцлах.

## **8 Бусад**

- 8.1 Энэхүү журмын 3.1 дэхь заалтын дагуу зах зээл үүсгэгчээр ажиллах тохиолдолд тухайн гишүүний зах зээлийг нь үүсгэх үнэт цаасны арилжааны шимтгэлийг 20 хүртэл хувиар хөнгөлж болно.
- 8.2 Бирж нь зах зээл үүсгэгчдийн жагсаалт, түүнд орсон өөрчлөлтийн талаар цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

\*\*\*\*\*



## Зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх өргөдлийн маягт

№	Мэдээллийн төрөл	
1	Гишүүн ҮЦК-ийн нэр	
2	Өргөдөлтэй холбоотойгоор харилцах этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл	
3	Зорилтот үнэт цаасны нэр, төрөл	
4	Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан бол тухайн үнэт цаас гаргагчийн нэр	
5	Гэрээний хугацаа	
6	Санхүүгийн үзүүлэлтүүд, хавсралт	
	- Санхүүгийн тайлан	
	- Тухайн үнэт цаас гаргагчтай бизнесийн болон бусад холбоо хамааралтай эсэх талаар тайлбар, мэдэгдэл	
	- Хууль тогтоомж чанд мөрдөн ажиллах тухай гаргасан батламж	
	- Дилерээр ажиллах мэргэжилтний мэдээлэл	
- Журмын 2.1-д заасан шалгуур, шаардлагыг хангаж буйг нотлох бусад баримт материалууд		

### Зах зээл үүсгэгчтэй байгуулах гэрээ

20... оны ... дугаар  
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК /цаашид Бирж гэх/, түүнийг төлөөлж....., нөгөө талаас ".....ҮЦК" ХХК /цаашид Зах зээл үүсгэгч, хамтад нь Талууд гэх/-ийг төлөөлж ..... нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож 6 сарын хугацаатай байгуулав.

#### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Бирж нь "Зах зээл үүсгэх үйл ажиллагааны журам"-д заасан шалгуур, шаардлага хангасан гишүүн үнэт цаасны компанид зах зээл үүсгэгчээр ажиллах зөвшөөрөл олгож, зах зээл үүсгэх үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Талуудын хооронд үүсэх энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид Хороо гэх/, Биржээс баталсан журам, заавраар зохицуулна.
- 1.3. Гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, аль нэг талын санаачлагаар дуусгавар болно.
- 1.4. Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд, эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.

#### Хоёр. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Бирж дараах эрх эдэлнэ:
  - 2.1.1 Зах зээл үүсгэгчийн хууль, дүрэм журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Биржээс гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;
  - 2.1.2. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
  - 2.1.3 Бирж нь дараах тохиолдлуудад зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг түдгэлзүүлнэ.
  - 2.1.4 Зах зээл үүсгэгч нь энэхүү журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох журамд заасан арга хэмжээг авах;
  - 2.1.5 Бирж нь Зах зээл үүсгэгчийн журмыг тайлбарлах эрхтэй байна.
- 2.2. Биржийн хүлээх үүрэг:
  - 2.2.1 Зах зээл үүсгэгчийн журмын шаардлага хангасан гишүүн үнэт цаасны компанийг зах зээл үүсгэгчээр сонгож, гэрээ байгуулах;
  - 2.2.2 Гэрээний дагуу зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих.



- 2.3. Гишүүн нь дараах эрх эдэлнэ.
- 2.3.1 Журмын 3.1 дэхь заалтын дагуу зах зээл үүсгэгчээр ажиллах тохиолдолд тухайн үнэт цаасны арилжааны шимтгэлийг ... хүртэлх хувиар хөнгөлүүлэх эрхтэй;
- 2.3.2 Журмын 6-р зүйлд заасан онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд зах зээл үүсгэгчийн үүргээс чөлөөлөгдөж болно.
- 2.3.3 Журамд заасан нөхцөлд зах зээл үүсгэгчийн худалдах, худалдан авах захиалгын үнийн зөрүүг энэхүү журмын 4.1.2-т заасан хэмжээнээс 2 дахин нэмэгдүүлэх, захиалгын доод хэмжээг 2 дахин бууруулж болно.
- 2.4 Гишүүн нь дараах үүрэг хүлээнэ:
- 2.4.1 Гэрээний дагуу таваас ихгүй тооны үнэт цаасны арилжааны худалдах, худалдан авах захиалгыг энгийн арилжааны цагийн 50%-иас доошгүй хугацаанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 2.4.2 Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа нь харилцагчтай сонирхлын зөрчил үүсгэх тохиолдолд энэ талаар харилцагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 2.4.3 Зах зээл үүсгэгч нь үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг бусад захиалгын баримт материалаас тусгаарлаж, зохих бүртгэлийг хөтөлж, гурваас доошгүй жилийн хугацаанд хадгална.
- 2.5 Бирж нь зах зээл үүсгэгчдийн жагсаалт, түүнд орсон өөрчлөлтийн талаар цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 2.6 Гэрээг аль нэг тал нь дангаараа өөрчлөх эрхгүй ба талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 2.7 Энэхүү гэрээгээр тохиролцоогүй бусад асуудлыг Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар зохицуулна.
- 2.8 Гэрээний асуудлаар маргаан үүссэн тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрвэл асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 2.9 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

.....

Утас:  
Факс:  
Хаяг:

Утас:  
Факс:  
Хаяг: